



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/119

Сангийдалай

Сумын гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн анги шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59,1,21 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32,1,1, 32,1,2 дахь заалт, Монгол Улсын Шадар Сайдын 2017 оны 75 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бүтэц зохион байгуулалтыг хавсралтаар баталсугай.
2. Гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг томилгоожуулан гүйцэтгэх үүргийг тодорхойлж, бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бүлгийн дарга нарт тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж удирдлага зохион байгуулалтаар хангаж, бүрэлдэхүүнд сургалт дадлага зохион байгуулахыг сумын Онцгой комиссын орлогч дарга Г.Энхдэлгэр нарт тус тус үүрэг болгосугай.
3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын засаг даргын 2022 оны 05 сарын 04 -ний өдрийн А/64 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ЛХАГВАМАНДАЛ



482302237